



НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР  
ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ /НӨҮГ/

# УЛААНБААТАР ХОТЫН ЖДҮҮ ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АЖИЛ

*Нийслэлийн ЖДҮҮДТ-ийн захиалгаар  
"Хангарьд бат" ХХК хийж гүйцэтгэв.*

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

## АГУУЛГА

АГУУЛГА.....	1
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	2
1 СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ.....	3
1.1 Судалгааны зорилго, зорилт.....	3
1.1 Судалгааны дизайн.....	3
1.2 Мэдээлэл цуглуулалтын арга ба түүвэр.....	4
1.3 Судалгааны түүвэр, хамрах хүрээ.....	4
2 САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЦЭЭ БА ДЭМЖЛЭГ.....	5
2.1 САНХҮҮЖИЛТИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЦЭЭ.....	5
2.1.1 Үйлдвэрлэлийн салбарын санхүүжилтийн хэрэгцээ.....	7
2.1.2 Үйлчилгээний салбарын санхүүжилтийн хэрэгцээ.....	9
2.1.3 Худалдааны салбарын санхүүжилтийн хэрэгцээ.....	10
2.2 Санхүүжилтийн хугацаа.....	11
2.3 Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа.....	11
3 ДҮГНЭЛТ, САНАЛ.....	13

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тоон судалгааны түүврийн хэмжээ .....	4
Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан голлох бизнесийн төрлүүд .....	5
Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан бизнесийн салбаруудын голлох үзүүлэлтүүд, нэгдсэн байдлаар 6	
Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн салбарын санхүүжилтын хэрэгцээ, ₮ .....	7
Хүснэгт 6. Үйлчилгээний салбарын санхүүжилтийн хэрэгцээ, ₮ .....	9
Хүснэгт 7. Худалдааны салбарын компаниудын санхүүжилтийн хэрэгцээ .....	10

# 1 СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

## 1.1 Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгаа нь бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн нөхцөл байдлыг судлан тодорхойлох, (ii) тэдгээрийн санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох гэсэн үндсэн хоёр зорилготой. Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

БЖДБЭ-дийн бизнесийн суурь нөхцөл байдлыг тодорхойлох:

- ✓ Санхүүгийн чадавх, санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшнийг тодорхойлох
- ✓ Бизнес эрхлэгчдийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын суурь түвшнийг тодорхойлох;

БЖДБЭ-дийн санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох:

- ✓ Санхүүгийн үйлчилгээний хэрэгцээ, үндсэн шаардлагыг тодорхойлох
- ✓ Бизнес тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга зам, дэмжих боломжуудыг тодорхойлох

## 1.1 Судалгааны дизайн

БЖДБЭ-дийн санхүүгийн нөхцөл байдал ба санхүүгийн хэрэгцээг тодорхойлох үндсэн хоёр зорилгын хүрээнд тоон судалгааны аргыг ашиглалаа.

Төслийн суурь үзүүлэлтүүд хүрээнд борлуулалтын орлого, орлогын өсөлт, борлуулалтын орлогыг хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийн суурь түвшний мэдээллийг цуглуулсан. Цаашид эдгээр суурь үзүүлэлтийг төслийн явцын болон эцсийн үнэлгээний үр дүнтэй харьцуулж, төслийн үр өгөөжийг тооцох юм. Бизнесийн санхүүгийн хэрэгцээ тодорхойлох судалгааны хүрээнд бизнес эрхлэгчдийг чадавхжуулахад ямар хэмжээ, хүү, хугацаатай санхүүжилт шаардлагатай байгааг судаллаа. Энэхүү мэдээлэлд үндэслэн хөнгөлөлттэй санхүүгийн зээлийн үйлчилгээг үзүүлэх үндсэн суурь судалгаа болох юм.

*Зураг 1. Судалгааны хүрээ*



## 1.2 Мэдээлэл цуглуулалтын арга ба түүвэр

Судалгааны мэдээллийг тоон (асуумж судалгаа)-ны аргыг ашигласан. Зорилтод хороодын БЖДБЭ-дийн төлөөллөөс асуумжийн аргаар мэдээлэл цуглуулсан. Асуумж судалгаанд оролцогчдоос санамсаргүйгээр дүүрэг бүрээс төлөөлөл ярилцаж мэдээллийг цуглуулсан. Түүнчлэн цугларсан мэдээллийг баталгаажуулах, олон талын эх сурвалжийн мэдээлэлтэй нэгтгэн, шинжлэх зорилгоор холбогдох тоо статистик болон баримт бичгүүдтэй танилцаж, шаардлагатай шинжилгээг гүйцэтгэсэн.

## 1.3 Судалгааны түүвэр, хамрах хүрээ.

Төсөлд Улаанбаатар хотын 300 бизнес эрхлэгчдийг судалгаанд хамрууллаа. Ингэхдээ дараах шалгууруудыг ашигласан. Үүнд:

- Түүвэр байршлын хувьд тэнцвэртэй төлөөлөлтэй байх
- Нийгмийн бүлгүүдийг тэнцвэртэй хамруулах
- Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт бизнес эрхэлдэг байх

Түүврийн тархалтыг жигд байлгах үүднээс зорилтот төвийн 6 дүүрэг бүрээс 150, алслагдсан 3-н дүүргээс 300 ЖДБ эрхлэгчдийг судалгаанд хамруулсан. Түүврийн хэмжээг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Тоон судалгааны түүврийн хэмжээ

ТООН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР		Түүвэр
Дүүрэг		Асуумж
Төвийн дүүрэг	Баянгол	45
	Баянзүрх	45
	Сонгинохайрхан	45
	Сүхбаатар	45
	Хан-Уул	45
	Чингэлтэй	45
Алслагдсан дүүрэг	Багануур	10
	Багахангай	10
	Налайх	10
<b>Нийт</b>		<b>300</b>

## 2 САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЦЭЭ БА ДЭМЖЛЭГ

Санхүүжилтийн хэрэгцээг БЖДБЭ үйл ажиллагааны салбарын ангиллыг тодорхойлохын тулд хуулийн үндсэн ангилал байдаг. Бизнес эрхэлдэг үйл ажиллагааны төрлийг ҮСХ-ны “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” -ын дагуу 9 чиглэлд ангилсан байдаг. Энэ ангиллаа ерөнхийд нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт хуваан үзэж, ерөнхий үр дүнгүүдийг тооцов. Судалгаанд оролцогчдыг үйл ажиллагааны салбараар нь ангилж үзвэл үйлдвэрлэл эрхлэгчид 59.4%, үйлчилгээнийх 19%, худалдааны салбарынхан 21.7%-ийг тус тус эзэлж байна.

### Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан голлох бизнесийн төрлүүд


№	Салбар	Эзлэх хувь
<b>Үйлдвэрлэлийн салбар</b>		<b>53%</b>
1	Гар урлал	12%
2	Гутал, хувцас үйлдвэрлэл	22%
3	Тавилга, модон эдлэл үйлдвэрлэл	9%
4	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7%
5	Хөдөө аж ахуй ба бусад	3%
<b>Үйлчилгээний салбар</b>		<b>24%</b>
6	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	6%
7	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	18%
<b>Худалдааны салбар</b>		<b>23%</b>
8	Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад бөөний болон жижиглэн худалдаа	19%
9	Моторт тээврийн хэрэгсэл, мотоцикл, авто сэлбэг худалдаа, засвар, үйлчилгээ	4%
<b>Нийт</b>		<b>100%</b>

### 2.1 САНХҮҮЖИЛТИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЦЭЭ

Бид судалгаанд хамрагдсан нийт 300 бизнес эрхлэгчдээс тоног төхөөрөмж хэрэгтэй гэсэн 84% буюу 252 бизнес эрхлэгчийн үр дүнд үндэслэн шинжилгээ хийв.

БЖДБЭ-ийн 16% нь 10 саяас доош төгрөгийн санхүүжилт, 11-30 сая төгрөгийн санхүүжилтийг 19%, 31-60 сая төгрөгийн санхүүжилтийг 24%, 61-100 сая төгрөгийн санхүүжилтийг 16% нь хүсэж байна. Нийт нийт БЖДБЭ-ийн 75% байна.

Зураг 2. БЖДБЭ-ийн хүссэн санхүүжилтын хэмжээ



Бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн одоогийн нөхцөл байдал болон цаашдын хэрэгцээг тоон утгаар нэгтгэн харуулав. Жилийн борлуулалтын орлого болон дундаж санхүүжилтийн хэрэгцээг тооцохдоо дундаж утгыг ашигласан.

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан бизнесийн салбаруудын голлох үзүүлэлтүүд, нэгдсэн байдлаар

Салбар	2022 борлуулалт (III улирлын байдлаарх дундаж орлого)	2021 борлуулалт (III улирлын байдлаарх)	Орлогын өөрчлөлт	Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ
Үйлдвэрлэл	20,691,849	16,481,548	26%	28,730,243
Үйлчилгээ	33,014,544	25,137,310	31%	22,006,738
Худалдаа	37,394,939	29,113,384	28%	21,710,768
<b>Бүгд</b>	<b>30,367,111</b>	<b>23,577,414</b>	<b>28%</b>	<b>24,149,250</b>

Дундажлаж авч үзвэл Үйлдвэрлэлийн салбарт 29 сая, Үйлчилгээний салбарт 22 сая, Худалдааны салбарт 21 сая төгрөг байна. Салбарын онцлогоос хамаарч дээд, доод хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал үйлдвэрлэлийн салбарт тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, Худалдаа, үйлчилгээний салбарт эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага өндөр байна.

Бизнес эрхлэгчдийн 15% нь ямар нэг тоног төхөөрөмжийн шаардлагагүйг, ашигладаггүй байна. Эдгээр нь гол төлөв худалдааны салбарт бизнес эрхлэгчид байна. Харин үйлдвэрлэлийн салбараас эсгий, наамал зэрэг гар урлал, цэцэг, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт үсчин, гоо сайхан, хүнс, барааны худалдаан бизнес эрхлэгчид санхүүжилтийн хэрэгцээ дундаж түвшинд байна.

Бизнес эрхлэгчдийн 76% нь **бүхий л салбарын бизнес эрхлэгчид санхүүжилтийн хэрэгцээгээ маш чухал, санхүүжилт авах шаардлагатай гэж үзсэн.**

Сүүлийн 2 жилийн хугацаанд санхүүжилт авсан бизнес эрхлэгчид 38%-тай байна. Санхүүжилт аваагүй бизнес эрхлэгчдийн тоо өндөр байгаа нь эдийн засгийн хямрал болон үйл ажиллагааны идэвхжил сул байсантай холбоотой.

Хэдийгээр БЖДБЭ-чид дунджаар 24 сая төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй ч 2022 оны 3-р улирлын байдлаарх борлуулалтын орлого нь 30.4 сая төгрөг байна. Иймд борлуулалтын орлогоороо дараагийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх хөрөнгө оруулалт хийх боломж хомс байгааг харуулж байна.

### **2.1.1 Үйлдвэрлэлийн салбарын санхүүжилтийн хэрэгцээ**

Одоо дээрх үр дүнг салбар бүрээр нарийвчлан авч үзье. Судалгаанд хамрагдсан энэ салбарын бизнес эрхлэгчдийн жилийн борлуулалтын дундаж орлого 2021 онд 16 сая орчим байсан бол 2022 оны 3-р улирлын байдлаар 20.1 сая төгрөг болж 24% өсжээ.

*Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн салбарын санхүүжилтын хэрэгцээ, ₮*

№	Салбар	Борлуулалтын дундаж орлого		Шаардлагатай санхүүжилт
		2022	2021	
1	Хувцас үйлдвэрлэл	14,168,730	7,682,957	20,053,200
2	Гар хийц	29,362,500	18,062,167	25,821,300
3	Тавилга, модон эдлэл үйлдвэрлэл	37,307,292	32,159,792	52,605,286
4	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15,457,000	13,514,000	28,050,000
5	Хөдөө аж ахуй ба бусад	7,163,725	10,988,825	17,121,429
	<b>Үйлдвэрлэлийн салбар</b>	<b>20,691,849</b>	<b>16,481,548</b>	<b>28,730,243</b>

Үйлдвэрлэлийн салбарын тоног төхөөрөмжийн хэрэгцээг бизнесийн төрлөөр ангилан харвал:

- Хувцас үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулж буй бизнес эрхлэгчид олон байдаг билээ. Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ бусад бизнесийн төрлүүдтэй харьцуулахад бага буюу 20 сая төгрөг байна. Тэдний одоогийн ашиглаж буй тоног төхөөрөмжүүд нь муудсан учраас шинэ төхөөрөмж авах, эргэлтийн бараа бүтээгдэхүүн авах хэрэгцээ өндөр байна. Тоног төхөөрөмжийн хувьд шулуун оёдлын машин, цахилгаан оёдлын машин, хэрээсний машин, зузаан оёдол хийх машин, хэв дарагч машин, нүх гаргагч гэх мэт аль нэг



төрлөөр оёх оёдлын машиныг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр бүтээгдэхүүний чанар сайжирч, нэр төрлөө нэмэгдүүлэх боломжтой болох юм.

- Гар хийцийн бизнест металл гар хийцийн зүйлс, эсгий урлал, бэлэг дурсгалын зүйлс хийдэг бизнес эрхлэгчид байна. Эсгийгээр урлаачдын хувьд оёх, самнах, хэв хийх машин, уурын индүү, нарийн оёдлын машин зэрэг тоног төхөөрөмжүүд шаардлагатай бол металлаар урлаачдын хувьд токарийн машин, туузан наалтын машин, хагас автомат гагнуурын болон лазерын аппарат, мөнгө хайлуулах, цутгах зэрэг олон төрлийн тоног төхөөрөмж, тэдгээрийг авах шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ өндөр байна. Санхүүжилт хийж төхөөрөмж авснаар хөдөлмөрөө хөнгөвчилж, бүтээгдэхүүний өнгө үзэмжийг сайжрах юм.

- Тавилга, модон эдлэл, вакум цонх үйлдвэрлэл нь харьцангуй өртөг өндөртэй бизнес тул шаардлагатай тоног төхөөрөмжийн үнэлгээ ч өндөр байна. Хамгийн өндөр дүнтэй буюу дунджаар 52.6 сая төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй байна. Тэд энэ үнийн дүнгийн 15%-ийг дунджаар өөрсдөөсөө санхүүжүүлэх боломжтой байна. Санхүүжилтээр олон янз ба хөрөө, рам зэрэг мужааны хэрэгслүүд, наагч, будагч хэрэгсэл, зүлгүүрийн машин зэрэг олон төхөөрөмж авах хэрэгцээтэй байна. Мөн эргэлтийн хөрөнгө, үйл ажиллагааны зардал, түгээлтийн машин зэрэгт санхүүжилт шаардлагатай байна.

- Хүнсний үйлдвэрлэгчдийн хувьд орлогын бууралт бусад бизнесийн салбаруудтай харьцуулахад харьцангуй бага байна. Шаардлагатай хөрөнгө оруулалтын дундаж дүн 28 сая төгрөг байна. Санхүүжилтээр авах тоног төхөөрөмжийн хувьд бууз банш хийгч машин, хөргөгч, хөлдөөгч, савлах, вакумдах машин, гурил зуурагч, хэрчигч зэрэг байна. Эдгээр тоног төхөөрөмж нь хуучирч муудсан эсвэл байхгүй тул шинээр авснаар үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх, үйл ажиллагаа өргөжих боломжтой байна.

- Хөдөө аж ахуй болон бусад салбарт газар тариалан, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдээс гадна хэвлэх үйлчилгээ, бусад чиглэлийн үйлчилгээний бизнесийн төрлүүд багтаасан. Энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн хүйсийн хувьд ялгаагүй байна. Эдгээр чиглэлийн бизнесийн жилийн борлуулалтын орлого маш бага хэмжээнд байна. Судалгаанд хамрагдсан ХАА-н чиглэлд бизнес эрхлэгчид нь өрхийн үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр төмс, хүнсний ногоо, хүлэмж, цэцэг тарих зэрэг үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдний одоо ашиглаж байгаа тоног

төхөөрөмж гэх зүйл бараг байхгүй тул тоног төхөөрөмж нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр байна. Санхүүжилт авснаар хүлэмжийн материал, усалгааны тоног төхөөрөмж, машин механизм болон бусад жижиг гар багаж хэрэгслүүд авахаар төлөвлөсөн байна. Тэд дунджаар 17 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэжээ.

### 2.1.2 Үйлчилгээний салбарын санхүүжилтийн хэрэгцээ

Энэ салбарын жилийн борлуулалтын дундаж орлого 2021 онд 25 сая орчим байсан бол 2022 онд 33 сая болжээ. Шаардлагатай санхүүжилтийн дундаж хэмжээ 22 сая төгрөг бөгөөд борлуулалтын орлоготой нь харьцуулбал өөрсдөө санхүүжүүлэх боломж бага байна. Тухайлбал, гар утас, компьютер засвар, үсчин зэрэг үйлчилгээнүүдийн техник, тоног төхөөрөмж хурдан шинэчлэгдэж байдаг тул сүүлийн үеийн техникүүдийг аль болох хурдан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлага бий болдог байна. Гэвч хуримтлал үүсгэж чаддаггүй, өндөр дүнтэй худалдан авалтыг санхүүжүүлэх боломжгүй байдаг байна.

Хүснэгт 5. Үйлчилгээний салбарын санхүүжилтийн хэрэгцээ, ₮

	Салбар	Борлуулалтын дундаж орлого		Шаардлагатай санхүүжилт
		2022	2021	
1	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоол	16,761,111	12,969,444	27,950,416
2	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	20,337,092	14,193,139	20,856,612
	<b>Үйлчилгээний салбар</b>	<b>33,014,544</b>	<b>25,137,310</b>	<b>22,006,738</b>

- Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлого 16 сая төгрөг бөгөөд энэ нь өмнөх оноос 22% өсөлттэй үзүүлэлт юм. Гэвч энэ чиглэлийн бизнес эрхлэгчдэд 27.9 сая төгрөгийн санхүүжилтийн хэрэгцээ байгаа нь одоогийн борлуулалтын орлогоосоо санхүүжүүлэх боломжгүй нөхцөлд байна. Энэ төрлийн бизнес эрхлэгчдэд том оврын тогоо, шарах шүүгээ, зориулалтын вандан ширээ, хөргөгч, хөлдөөгч, сав угаах машин, угаалгын машин зэрэг тоног төхөөрөмжүүд, өдөр тутмын үйл ажиллагааны бараа бүтээгдэхүүн авахад санхүүжилт шаардлагатай байна.

- Үйлчилгээний бусад үйл ажиллагаа гэсэн ангилалд үсчин, маникюр, гоо сайхны үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байна. Тэдэнд шаардлагатай тоног, төхөөрөмжид уурын аппарат, үсний химийн аппарат, шарагч гэрэл, угаалтуур, педикюрийн суудал, сандал, массажны ор зэрэг төхөөрөмжүүдийг санхүүжилтээр

авах шаардлагатай байна. Санхүүжилт авснаар бүдүүн оёдлын машин, цавууны машин, индүүддэг машин, булчин тэлэгч, боогч, шахагч машин зэрэг олон төрлийн тоног, төхөөрөмж авах хэрэгцээтэй байна. Гар утас засварын үйлчилгээнд дэлгэц наагч, лазер машин, микроскоп зэрэг шинэ технологийн тоног төхөөрөмжүүд нэвтрүүлэх хэрэгцээтэй байдаг байна.

### 2.1.3 Худалдааны салбарын санхүүжилтийн хэрэгцээ

Энэ салбарт бизнес эрхлэгчдийн жилийн борлуулалтын дундаж орлого 29.1 сая төгрөгөөс 37.4 сая төгрөг болж өмнөх оноос 21%-аар өсжээ. Шаардлагатай санхүүжилтийн дундаж хэмжээ 21.7 сая төгрөг бөгөөд үүнийг борлуулалтын орлоготой нь харьцуулахад өөрсдөө 40%-ийн санхүүжилт хийх боломжтой байна. Худалдааны салбарынхны хувьд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарынхантай харьцуулахад тоног, төхөөрөмжийн хэрэгцээ бага боловч эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хэрэгцээ өндөр байна.

*Хүснэгт 6. Худалдааны салбарын компаниудын санхүүжилтийн хэрэгцээ*

№	Салбар	Борлуулалтын дундаж орлого		Шаардлагатай санхүүжилт
		2022	2021	
1	Бөөний болон жижиглэн худалдаа	57,078,215	34,653,275	13,906,200
2	Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн авто сэлбэг худалдаа, засвар, үйлчилгээ	24,795,000	20,001,944	35,647,500
	<b>Худалдааны салбар</b>	<b>37,394,939</b>	<b>29,113,384</b>	<b>21,710,768</b>


- Бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдийн борлуулалтын орлого 2021 оноос 2022 онд 40%-аар өсжээ. Гэвч худалдааны төрлөөс хамаарч ялгаатай үр дүнгүүд ажиглагдаж байна. Хүнсний худалдаа эрхлэгчдийн хувьд тоног төхөөрөмжийн хэрэгцээ арай өндөр бөгөөд гол төлөв хөлдөөгч, хөргүүр, вакумдагч, мах зүсэгч машин зэрэг тоног, төхөөрөмж санхүүжилтээр авах шаардлагатай байна. Барилгын материалын худалдааны борлуулалтын орлого мөн өссөн байна. Хэрэгцээт тоног төхөөрөмжид гол төлөв ачаа ачих машин, техник хэрэгслүүдийг нэрлэсэн тул шаардлагатай санхүүжилтийн хэмжээ харьцангуй өндөр байна.
- Моторт тээврийн хэрэгслийн сэлбэгийн худалдаа, засвар үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтын дундаж орлого 2022 онд өмнөх оноос 17%-аар өссөн үзүүлэлттэй байна. Тэд санхүүжилт авснаар компрессор, данхраат, дрилл, хийлэгч, лифт, градустай хөрөө, наалтын машин, усан буу, тоос сорогч, зэрэг тоног

төхөөрөмжийг авах шаардлагатай. Энэ тоног төхөөрөмжүүд болон эргэлтийн хөрөнгөд дунджаар 35.6 сая төгрөг хэрэгцээтэй байна.

## 2.2 Санхүүжилтийн хугацаа

Энэхүү бүлэгт санхүүжилт авахад шаардлагатай хугацааг харуулж байна. БЖДБЭ-ийн 5% нь 1 жил, 25% нь 2 жил, 37% нь 3 жил байна. Өөрөөр хэлбэл 3-н жил хүртэлх санхүүжилттэй байхыг 67% нь хүсжээ. Арилжааны банкнуудын 3-н жилийн хугацаатай зээл нь дундаж хугацаа бөгөөд эргэлтийн хөрөнгө, хурдан эргэлттэй жижиг үйлдвэрлэлүүдэд боломжтой хугацаа байна. Харин үйлдвэрлэлийн санхүүжилт өндөр, удаан эргэлттэй томоохон үйлдвэрүүдэд 3-н жил хангалтгүй байна.


Зураг 3. Зээлийн санхүүжилтийн хүсэж буй хугацаа



## 2.3 Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа

Үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой суурилуулж үйл ажиллагаагаа эхлүүлэхэд тодорхой хугацаа шаарддаг. Тиймээс зээлийн үндсэн төлбөрөөс хэдэн сарын хугацаанд чөлөөлүүлэх шаардлагатай байгааг судалгаагаар тодорхойлсон. БЖДБЭ-ийн 26% нь 1 сар, 34% нь 3-н сар, 22% нь 6-н сар, 18% нь 9-н сар үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлтэй байна.

Зураг 4. Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөхийг хүсэж буй хугацаа



### 3 ДҮГНЭЛТ, САНАЛ

- Төсөлд Улаанбаатар хотын 300 бизнес эрхлэгчдийг судалгаанд хамрууллаа. Ингэхдээ дараах шалгууруудыг ашигласан. Түүврийн тархалтыг жигд байлгах үүднээс зорилтот төвийн 6 дүүрэг бүрээс 150, алслагдсан 3-н дүүргээс 300 ЖДБ эрхлэгчдийг судалгаанд хамруулсан. Иймд эх олонлогийг төлөөлөх чадвартай түүврээс судалгааг авсан.
- БЖДБЭ-ийн 16% нь 10 саяас доош төгрөгийн санхүүжилт, 11-30 сая төгрөгийн санхүүжилтийг 19%, 31-60 сая төгрөгийн санхүүжилтийг 24%, 61-100 сая төгрөгийн санхүүжилтийг 16% нь хүсэж байна. Нийт нийт БЖДБЭ-ийн 75% байна. Дундажлаж авч үзвэл Үйлдвэрлэлийн салбарт 29 сая, Үйлчилгээний салбарт 22 сая, Худалдааны салбарт 21 сая төгрөг байна. Салбарын онцлогоос хамаарч дээд, доод хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал үйлдвэрлэлийн салбарт тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, Худалдаа, үйлчилгээний салбарт эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага өндөр байна.
- Үйлдвэрийн салбарын бизнес эрхлэгчдийн жилийн борлуулалтын дундаж орлого 2021 онд 16 сая орчим байсан бол 2022 оны 3-р улирлын байдлаар 20.1 сая төгрөг болж 24% өссөн байна.
- Үйлчилгээний салбарын жилийн борлуулалтын дундаж орлого 2021 онд 25 сая орчим байсан бол 2022 онд 33 сая болжээ. Шаардлагатай санхүүжилтийн дундаж хэмжээ 22 сая төгрөг бөгөөд борлуулалтын орлоготой нь харьцуулбал өөрсдөө санхүүжүүлэх боломж бага байна. Тухайлбал, гар утас, компьютер засвар, үсчин зэрэг үйлчилгээнүүдийн техник, тоног төхөөрөмж хурдан шинэчлэгдэж байдаг тул сүүлийн үеийн техникүүдийг аль болох хурдан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлага бий болдог байна. Гэвч хуримтлал үүсгэж чаддаггүй, өндөр дүнтэй худалдан авалтыг санхүүжүүлэх боломжгүй байдаг байна.
- Худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн жилийн борлуулалтын дундаж орлого 29.1 сая төгрөгөөс 37.4 сая төгрөг болж өмнөх оноос 21%-аар өсжээ. Шаардлагатай санхүүжилтийн дундаж хэмжээ 21.7 сая төгрөг бөгөөд үүнийг борлуулалтын орлоготой нь харьцуулахад өөрсдөө 40%-ийн санхүүжилт хийх боломжтой байна. Худалдааны салбарынхны хувьд үйлдвэрлэл болон

үйлчилгээний салбарынхантай харьцуулахад тоног, төхөөрөмжийн хэрэгцээ бага боловч эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хэрэгцээ өндөр байна.

- БЖДБЭ-ийн 5% нь 1 жил, 25% нь 2 жил, 37% нь 3 жил байна. Өөрөөр хэлбэл 3-н жил хүртэлх санхүүжилттэй байхыг 67% нь хүсжээ. Арилжааны банкнуудын 3-н жилийн хугацаатай зээл нь дундаж хугацаа бөгөөд эргэлтийн хөрөнгө, хурдан эргэлттэй жижиг үйлдвэрлэлүүдэд боломжтой хугацаа байна. Харин үйлдвэрлэлийн санхүүжилт өндөр, удаан эргэлттэй томоохон үйлдвэрүүдэд 3-н жил хангалтгүй байна.
- БЖДБЭ-ийн 26% нь 1 сар, 34% нь 3-н сар, 22% нь 6-н сар, 18% нь 9-н сар үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлтэй байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой суурилуулж үйл ажиллагаагаа эхлүүлэхэд тодорхой хугацаа шаарддаг. Тиймээс зээлийн үндсэн төлбөрөөс 3 сарын хугацаанд чөлөөлөх боломжтой байна.